



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/328

Бсөнбулаг

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 2020 оны "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 10 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийх тухай" 21 дүгээр тогтоол, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй "Говь-Алтай аймгийн сүм хийд, лам нарын бүртгэл болон хязгаарыг даван нүүдэллэгсдийн эмхэтгэл" сэдэвт судалгааны ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Гэрээний зардалд шаардагдах 18,995,000 (арван найман сая есөн зуун ерэн таван мянга) төгрөгийг "Говь-Алтай аймгийн сүм хийд, лам нарын бүртгэл болон хязгаарыг даван нүүдэллэгсдийн эмхэтгэл"-ийн батлагдсан эх үүсвэрээс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/ My Documents A-4 doc

0201002205

